



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Судалгааны ажлын тэргүүлэх чиглэлүүдийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын судалгааны ажлын үр дүн, чанарыг сайжруулах, албан хаагчдын мэргэжлийн чиглэлээр давтан суралцах, эрдэм шинжилгээний ажил хийх сонирхлыг нэмэгдүүлэх, судалгаанд суурилсан шийдвэр гаргалт, технологи нэвтрүүлэлтийг дэмжих зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Олон улсын хөгжлийн чиг хандлага, салбарын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тэргүүлэх чиглэлийг 5 жил тутамд шинэчлэн батлуулж байхыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд даалгасугай.

3. Магистр, докторын зэрэг олгох гадаад, дотоодын их, дээд сургуульд хавсралтад заасан тэргүүлэх чиглэлээр элсэн суралцах ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдад дараах дэмжлэг үзүүлэхийг тус газрын харьяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай. Үүнд:

-Дэлхийн цаг уурын байгууллага, бусад харилцаат байгууллагын шугамаар зохиогдох эрдэм шинжилгээний хурал, уулзалт, зөвлөгөөнд эхний ээлжид оролцуулах,

-Архив, мэдээллийн сангаас судалгааны чиглэлтэй шууд холбогдох мэдээллийг хязгаарлалтгүй ашиглах,

-Төрийн албан хаагчийн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэхэд судалгааны ажлын үр дүнг харгалзах,

-Ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд судалгаа хийх онцлог хугацааг харгалзах,

-Судалгаа, туршилт хийх шаардлагатай багаж төхөөрөмжийг ашиглуулах,

-Судалгааны өгүүлэл бичих, хэвлүүлэх зардалд дэмжлэг үзүүлэх.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аудитын хэлтэс /Р.Бадмаадорж/-т даалгасугай.


ДАРГА



Э.БАТТУЛГА

151250273

d:\2025\а тушаал\05.27-93.docx



Судалгааны ажлын тэргүүлэх чиглэлүүд

- Цаг агаарын тоон прогноз, загварчлал, бичил болон бэсрэг хэмжээст үзэгдэл
- Машин сургалт, хиймэл оюун ухааны хэрэглээ, статистик загварчлал
- Хиймэл дагуул, радарын мэдээ боловсруулалт, өгөгдлийн ассимиляц
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр дүнг тооцох, загварчлал
- Сар, улирлын прогноз, технологи, дэлхийн хэмжээст загварчлал
- Хэрэглээний болон хотын уур амьсгал, сэргээгдэх эрчим хүчний үнэлгээ
- Бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлт, нөлөөлөл, эмзэг байдал эрсдэл
- Бэлчээр, таримал ургамал, экосистемийн загварчлал
- Хиймэл дагуулын мэдээ боловсруулалт, шийдвэр гаргах систем
- Гол мөрний динамик загвар, үерийн халилтын загварчлал
- Шороон шуурга, агаарын бохирдол, орчны загварчлал
- Цөлжилт, газрын доройтол, гангийн нөлөөлөл, эмзэг байдал эрсдэлийн судалгаа
- Эрт сэрэмжлүүлгийн систем
- Ой хээрийн түймрийн эрсдэлийн тархалтын загварчлал, тооцоолол
- Нөлөөлөлд суурилсан урьдчилан сэргийлэх мэдээ

----oOo----